

ЗҮҮН ХОЙД АЗИЙН НҮҮРСНИЙ ЭРЭЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТ

В. Энхболд*

Товч утга

Дэлхий дахинаа нүүрсний эрэлт 2035 он хүртэлхи хугацаанд их байх төлөвтэй. Дэлхийн нийт нүүрсний олборлолтын 53%, коксжих нүүрс олборлолтын 60% нь ЗХА-ийн бүс нутагт ноогдож байна. Хэдийгээр ЗХА-ийн бүс нутаг нүүрсний олборлолтоор дэлхийд давамгайлж байгаа ч тус бүс нутгийн Хятад, Япон, Өмнөд Солонгос зэрэг оронд нүүрсний хэрэгцээ их, цаашид ч өсөх хандлагатай байна. Монгол улс нүүрсний арвин нөөцтэй ба нүүрсний экспорт нэмэгдэж байна. ОХУ-ын хувьд эрчим хүчний шинэ стратегийн дагуу оросын нүүрсний экспорт алгуур алс дорнод тийш ЗХА-ийн зах зээлд чиглэж байна. Өнөөдөр Орос-Хятадын нүүрсний салбарын хамтын ажиллагаа улам бүр нягтарч байгаа, мөн ОХУ-ын засгийн газар Сибирь дэх нүүрсний ордуудаа ашиглах зорилт тавьсан зэрэг нь ОХУ ойрын ирээдүйд Хятад болон ЗХА-ийн зах зээлд гол нүүрс нийлүүлэгч байх магадлалтай. Улмаар нөөц баялаг болон газар зүйн ойр дөт байршил зэргээс хамаарч Монгол, ОХУ-нь ЗХА-ийн зах зээлд нүүрс экспортлогчид төдийгүй гол өрсөлдөгчид байх төлөв ажиглагдаж байна.

Түлхүүр үг: ЗХА, нүүрсний эрэлт, нүүрсний экспорт, коксжих нүүрс.

1. Зүүн хойд азийн нүүрсний эрэлт:

2012 оны түвшинд дэлхийн нүүрсний баталгаажсан нөөц 861 тэрбум тонн байгаа ба 112 жилийн хугацаанд хэрэглэх боломжтой гэж Олон улсын эрчим хүчний зөвлөлөөс таамаг гаргажээ. Дэлхийн газрын тосны нөөц 46 жил, байгалийн хий 54 жил бөгөөд үүнтэй харьцуулахад нүүрсний нөөц харьцангуй их байна. Дэлхийн нүүрсний баталгаажсан нөөц¹ 2001 онд 985 тэрбум тонн байсан бол 10 жилийн хугацаанд ийнхүү 12,6%-иар багассан нь нүүрсний хэрэглээ жилээс жилд ихсэж байгааг нотлон харуулж байна. 2011 оны үзүүлэлтээр дэлхийн нийт нүүрс олборлолтын 53 хувь, коксжих

*В. Энхболд -МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийн докторант

нүүрс олборлолтын 60 хувь нь ЗХА бүс нутагт ноогдсон зэрэг нь тус бүс нутаг дэлхийн нүүрсний гол зах зээл болж байгааг гэрчилж байна. 2011 онд дэлхийн хэмжээнд 5.67 тэрбум тонн эрчим хүчний нүүрс олборлосны 50 орчим хувийг Хятад, 3.1 хувийг ОХУ-д олборложээ. Хятад улс 2011 онд дотооддоо олборлосон нүүрснээс гадна Индонез, Австрали, Вьетнам, Монгол зэрэг орнуудаас нэмж 146 сая тонн нүүрс худалдан авсан бол ОХУ-ын хувьд 110 сая тонн нүүрсийг Хятад, Энэтхэг, Япон болон Европын зах зээлд борлуулжээ. Харин Япон 121 сая тонн, Өмнөд солонгос 97 сая тонн нүүрс Индонези, Австрали, ОХУ, АНУ, Канадаас худалдан авчээ.


Коксжих нүүрсний хувьд 2011 онд дэлхий нийтэд 967 сая тонн нүүрс олборлосон ба үүнд Хятад- 52.1 хувь, ОХУ- 8.1 хувь, Монгол- 2.1 хувь тус тус эзэлжээ. Хятадын нүүрсний олборлолт өөрийн дотоодын хэрэгцээнд хүрэлцэхгүй байгаа тул нэмж 38 сая тонн коксжих нүүрсийг Австрали, Монгол, ОХУ-аас импортлосон ба Япон 54 сая тонн, Өмнөд Солонгос 32 сая тонн коксжих нүүрсийг Австрали, Индонез, ОХУ, Канад, АНУ зэрэг орнуудаас тус тус худалдан авчээ. Мөн онд Хятад 136 сая тонн, ОХУ 78 сая тонн хүрэн нүүрс олборлон дотоодын хэрэгцээнд нийлүүлжээ.

Дэлхийн эрчим хүчний нүүрс олборлолтын 53 хувь, коксжих нүүрс олборлолтын 60 хувь, хүрэн нүүрс олборлолтын 20 хувь нь ЗХА-ийн орнуудад ноогдож байна. Хэдийгээр дэлхийн нүүрс олборлолтын дийлэнх хувь нь тус бүс нутагт ноогдож байгаа ч бусад зах зээлээс 354 сая тонн эрчим хүчний нүүрс, 124 сая тонн коксжих нүүрс худалдан авсан нь нүүрсний хэрэгцээ их, цаашид ч өсөх хандлагатайг харуулж байна.

Ялангуяа Хятад дэлхийн нүүрсний хамгийн том олборлогч орон хэдий ч эдийн засгийн эрчимтэй өсөлтөөс хамаарч гадаадаас нүүрс худалдан авах хэрэгцээ шаардлага их байна.

2011 онд дэлхийн коксжих нүүрсний гол импортлогч орнууд

Зураг 1. (сая тонн)



Эх сурвалж: Дэлхийн нүүрсний холбоо

2011 оны ЗХА-ийн нүүрсний зах зээл Нүүрс олборлолт ба худалдаа.

Хүснэгт 1.

(сая тонн)

Орон	Эрчим хүчний нүүрс			Коксжих нүүрс			Хүрэн нүүрс		
	Олборлолт	Экспорт	Импорт	Олборлолт	Экспорт	Импорт	Олборлолт	Экспорт	Импорт
Хятад	2831	-	146	504	3	38	136	-	-
ОХУ	178	110	-	78	14	-	78	-	-
Япон	-	-	121	-	-	54	-	-	-
Өмнөд Солонгос	-	-	97	-	-	32	-	-	-
Монгол	-	-	-	20	20	-	-	-	-
Дэлхий нийт	5670	-	-	967	-	-	1041	-	-

Эх сурвалж: Дэлхийн нүүрсний холбоо

Хүснэгт 1-ээс үзэхэд ОХУ, Монгол улсын хувьд нүүрс олборлож, экспортолсон ба харин импортоор нүүрс аваагүй байна. Энэ утгаараа цаашид ЗХА-ийн зах зээлд Хятад, Япон, Өмнөд Солонгос зэрэг орнууд хэрэглэгч буюу импортлогч, харин Монгол, ОХУ зэрэг орнууд нийлүүлэгч буюу экспортлогчийн байр сууринд байх нь тодорхой болж байна.

Хятад улс 2001 онд ДХБ-д нэгдэн орохдоо зах зээлээ либералчлах талаар авсан үүрэг амлалтаа 2008 оноос бүрэн хэрэгжүүлж эхэлсэн ба энэ үйл явц нь Хятадад бизнесийн таатай орчин бүрдэж гадаадын шууд хөрөнгө оруулалт татах үндсэн угтвар болсон юм. Хятадад хөрөнгө оруулалтын урсгал идэвхжих тусам худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний цар хүрээ ихсэн, улмаар эдийн засгийн хурдацтай өсөлтийг дагуулсан нь эрчим хүчний үйлдвэрлэлийг цаашид улам бүр нэмэгдүүлэх шаардлага бий болгож байна. Харин хойд хөрш ОХУ-ын хувьд хорь гаруй жил хэлэлцээ хийсний эцэст 2011 онд ДХБ-д нэгдэн оров. ОХУ, Хятад ДХБ-д нэгдсэн нь Монгол улсын хувьд хоёр хөрш болон бүс нутгийн түнш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг олон улсын худалдааны стандарт, дэг жаяг, дүрмийн дагуу явуулах эрх зүйн орчинг бий болгов.

ЗХА-ийн нүүрсний гол хэрэглэгч болох Хятад, Япон, Өмнөд Солонгосын хооронд гурван талт Чөлөөт худалдааны хэлэлцээ²

Зүүн хойд азийн нүүрсний эрэлт ба нийлүүлэлт

эхэлсэн болон манай хоёр хөрш орон стратегийн түншлэлийг

2011 онд ЗХА-ийн орнуудын нүүрс импортолсон байдал
Хүснэгт 2.

	Нүүрс импортлогч орон	Нүүрсний импортын эх үүсвэр	Импортын хэмжээ (сая тонн)	Хувь (%)
1	Хятад ¹	Индонез	64,8	35,2
		Австрали	32,5	17,6
		Вьетнам	22,1	12,0
		Монгол	20,0	10,9
		ОХУ	10,6	5,7
		Канад	4,5	2,4
		Хятадын нийт импорт:	184,0	100%
2	Япон ⁴	Австрали	104,8	59,9
		Индонез	35,5	20,3
		ОХУ	11,4	6,5
		Канад	9,6	5,5
		АНУ	6,3	3,6
		Японы нийт импорт:	175,0	100%
3	Өмнөд солонгос ⁵	Австрали	44,7	34,6
		Индонез	40,3	31,2
		Канад	14,5	11,2
		ОХУ	12,7	9,8
		АНУ	6,1	4,7
		Өмнөд солонгосын нийт:	129,0	100%

Эх сурвалж: Хятад, Япон, Өмнөд Солонгосын гаалийн статистикийн мэдээнд үндэслэж нэгтгэв.

хөгжүүлж байгаа зэрэг нь ЗХА-ийн бүс нутагт эдийн засаг, бизнесийн тайтай орчинг бүрдүүлж байна. Тус бүс нутагт эдийн засгийн либералчлал эрчимжиж, бизнесийн орчин сайжирч байгаа нь Монгол улсын нүүрсний салбарын хөгжлийг улам бүр нэмэгдүүлж байна.

Хүснэгт 2-оос дүгнэлт хийхэд ЗХА-ийн зах зээлд Австрали, Индонезийн нүүрсний экспорт давамгайлж байна. Австралийн хувьд

эрчим хүчний болон коксжих нүүрс аль алийг экспортолж байгаа бол Индонезийн хувьд зөвхөн эрчим хүчний нүүрс экспортолж байна. Мөн Вьетнам Хятадад эрчим хүчний нүүрс экспортолж байгаа хэдий ч дотоодын өсөн нэмэгдэж буй хэрэгцээнээс хамаарч экспортонд хязгаарлалт хийх арга хэмжээ авч эхэлсэн. Хятадын нийт импортын 19.2 хувь, Японы импортын 39 хувь, харин Өмнөд Солонгосын импортын 20 хувь нь тус тус коксжих нүүрс байв. Хойд Америкийн экспорт Өмнөд Солонгосын импортын 15 хувийг эзэлсэн бол Хятад, Японы зах зээлд Хойд Америкийн нүүрсний экспорт дөнгөж 4 хувийг эзэлж байна.

Оросын нүүрс Өмнөд Солонгосын импортын 9.8 хувь, харин Хятад, Японы импортод 6 хувийг эзэлж байна. 2011 онд Монголын нүүрсний экспорт Хятадын нийт импортын 10.9 хувь эзэлсэн байна.

2. Монголын нүүрсний экспортын боломж.

ЗХА бүс нутагт эдийн засгийн таатай орчин бүрэлдэх үйл явцыг дагаад Монгол улсын уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байна. Үүний нэг тод жишээ нь 2012 оны Монгол улсын нийт экспортын 85 хувийг эрдэс түүхий эдийн экспорт эзэлсэн ба үүнд нүүрс 47 хувь болжээ.⁶ Уул уурхайн салбарын эрчимтэй хөгжил нь Монгол улсын эдийн засгийн хөгжлийг хурдасгаж, үүний үр дүнд 2008 онд 8 хувийн өсөлттэй байсан Монголын эдийн засаг 2012 онд 12.3 хувьд хүрсэн юм. 2012 оны урьдчилсан мэдээгээр Монголын уул уурхайн салбар ДНБ-ний 18.6-ийг үйлдвэрлэсэн бол нийт экспортын 87.7 хувь энэ салбарт ноогдож байна.


Монгол улс 2003 оноос анх нүүрс экспортолж эхэлсэн ба 2011 онд гадаад зах зээлийн тааламжтай байдал, ялангуяа Хятадын дотоод хэрэгцээний өсөлтөөс хамаарч нүүрсний экспортын оргил цэгт хүрсэн. Монгол улс 2008 онд 4.2 сая тонн нүүрс экспортолж байсан бол 2008 онд 18.2 сая тонн, 2011 онд 22.5 сая тонн экспортолсон. Харин 2012 онд экспорт буурсан нь коксжих нүүрс дэлхийн зах зээлийн үнэ унасан, Хятад улс дотоодын хэрэгцээгээ танасан зэрэгтэй холбоотой юм.

2012 онд Монгол улс 31.1 сая тонн нүүрс олборлож 20.1 сая тонныг экспортолсон⁷ бөгөөд нийт экспортын 47 хувь нь нүүрсний экспорт бүрдүүлжээ. Үндэсний статистикийн газрын мэдээлснээр 2012 онд Монголд үндэсний 6 компани нийт нүүрсний экспортын 96 хувийг экспортолсон байна. Үүнд: Энержи ресурс-26%, МАК-21%, Таван толгой-11%, Саус Гоби Сэндс-15%, Эрдэнэс ТТ-13%,

Зүүн хойд азийн нүүрсний эрэлт ба нийлүүлэлт

Мон Эн Ко- 4 % болжээ. Монгол улсын нүүрсний таамаг нөөц 173 тэрбум тоннд хүрсэн нь дэлхийн тогтоогдсон нүүрсний нөөц баялгийн 5-6 орчим хувь нь Монголд ноогдож байна гэж үзэх боломжтой юм. Монгол улс нүүрсний арвин нөөцтэй байгаа нь нүүрс хэрэглэгч улс орнууд болон хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээр татах боллоо.


Монгол улсын нүүрсний олборлолт ба экспорт
Зураг 2. (сая тонн)



Эх сурвалж: УГЕГ

УУЯ-аас гаргасан тооцоогоор Монгол улс 2015 онд 50 сая тонн, 2020 онд 65 сая тонн, 2025 онд 75 сая тонн нүүрс тус тус экспортлох ба гол зах зээл нь Хятад, дунд хугацаанд ЗХА-ийн орнууд байх юм. 2011 онд Монголын нүүрсний экспорт Хятадын нийт импортын 10.9 хувь эзэлсэн ба Хятадад нийүүлсэн коксжих нүүрсний хэмжээгээр Австралийг гүйцэж түрүүлсэн.

Зураг 3. Монгол улсын нүүрсний томоохон ордууд



Ухаа худгийн нүүрсний ордоос 19 мянган тонн баяжуулсан коксжих нүүрсийг ОХУ-ын алс дорнод дахь Восточный боомтоор дамжуулж Японд нийлүүлэх ачилт хийгдсэн нь Монгол ЗХА-ийн зах зээлд нүүрс нийлүүлэх эхний оролдлого байв. Гадаад зах зээлийн эрэлт хэрэгцээ нь Монгол улсын хувьд том боломж хэдий ч их хэмжээний нүүрс экспортлоход төмөр замын дэд бүтцийг өргөтгөх асуудал чухал юм. Энэ чиглэлд Монгол улсын төр, засгаас төмөр замын талаар баримтлах бодлого боловсруулан, бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлж эхэлж байна.

Монгол улс уул уурхайн томоохон ордыг төмөр замын сүлжээнд холбох асуудлаа ойрын үед шийдвэрлэх тохиолдолд Монголын нүүрс Хятад болон ЗХА-ийн зах зээлд их хэмжээгээр гарах бүрэн боломжтой гэж үзэж байна.

3. Орос-Хятадын нүүрсний салбарын хамтын ажиллагаа.

Манай хойд, урд хоёр хөршийн харилцаанд дулаан уур амьсгал орж, харилцаа нь эдийн засгийн агуулгаар улам бүр баяжиж байгаа нь Монголын зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж байна. 2010 оны 9 дүгээр сард Орос, Хятадын төрийн тэргүүн нар хоёр орны харилцааг “Стратегийн түншлэл”⁸-ийн хэмжээнд хөгжүүлэхээр тохиролцсон ба үүний дүнд 2012 оны байдлаар Орос-Хятадын худалдааны эргэлт 88 тэрбум ам.долларт хүрч, хөрөнгө оруулалт 4.1 тэрбум ам.доллар болов. Харилцан хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэг нь эрчим хүч үйлдвэрлэл, нүүрс олборлолт, байгалийн хий, нефть бүтээгдэхүүний хоолойн байгууламж, тээврийн дэд бүтцэд орсон байна.

ОХУ-ын коксжих нүүрсний ордууд

Зураг 2.



2012 оны 12 дугаар сард “Орос-Хятад эрчим хүчний салбарт хамтарч ажиллах хэлэлцээр”⁹-т хоёр орны засгийн газрын дэд тэргүүн нар гарын үсэг зурсан нь тус хоёр орны стратегийн түншлэлийн харилцаанд эрчим хүчний хамтын ажиллагаа, нэн ялангуяа газрын тос, байгалийн хий болон нүүрсний салбарт хамтран ажиллах асуудал чухал байр суурь эзэлж буйг нотлон харуулав.

Мөн Оросын эрчим хүчний сайд, Хятадын эрчим хүчний удирдах газрын удирдлагууд 2010 онд “Орос-Хятадын нүүрсний салбарт хамтарч ажиллах тухай хэлэлцээр”-т алс дорнодын Благовешенск хотноо гарын үсэг зурсан билээ. Энэ тохиролцооны дагуу Хятад улс ОХУ-д 6 тэрбум ам.долларын зээл олгох ба энэ зээлийг ОХУ нүүрсний салбарыг хөгжүүлэх, нүүрснээс шингэн түлш гаргах технологи нэвтрүүлэх төслүүдэд ашиглах ажээ. Мөн ОХУ Хятадад 25 жилийн хугацаанд нүүрс нийлүүлэхээр (эхний 5 жил тутам 15 сая тонн, дараагийн 20 жил тутам 20 сая тонн) тохиролцсон.¹⁰ Энэ зорилтод хүрэхийн тулд Орос-Хятадын хамтарсан “Огоджинскийн эрчим хүч” төрийн өмчит компанийг 2011 онд байгуулжээ. Энэ компани нь Амур мужийн Сэлэмскийн районд орших Огоджинскийн чулуун нүүрсний ордыг ашиглах зорилгоор 4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийж, улмаар 2014 онд 5 сая тонн нүүрс олборлох, 2019 оноос жил тутам 30 сая тонн олборлох төлөвлөгөөтэй ажиллаж байна. Мөн Кемеровод Караканы нүүрсний ордыг ашиглах Орос-Хятадын хамтарсан “Каракан инвест”¹¹ компани байгуулагдсан нь манай хоёр хөршийн нүүрсний салбарын хамтын ажиллагаа улам нягтарч байгааг харуулж байна.

ОХУ-ын 2030 он хүртэлхи эрчим хүчний стратеги нь алс дорнод руу чиглэж байгаа болон Орос-Хятадын нүүрсний салбарын нягт хамтын ажиллагаа зэрэг нь ЗХА-ийн бүс нутагт Монгол төдийгүй, ОХУ нүүрсний гол экспортлогч нийлүүлэгч байх өндөр магадлалтай юм.

**2020 оны байдлаар ОХУ-ын коксжих нүүрсний
олборлох хэмжээний төлөв**

Хүснэгт 3

	Коксжих нүүрсний одууд	Жилд олборлох хүчин чадал (сая тонн)
1	Апсацкое	6.8
2	Элегест	18.0
3	Элга	24.0
4	Межейгеское	9.0
5	Улуг хэм	12.5
6	Усунской 1	4.0
7	Усунской 3	4.5
	Нийт:	78.8

Эх сурвалж: IMC Montan

Монголын хойд хилийн ойролцоо орших ОХУ-ын эдгээр 7 коксжих нүүрсний ордын хүчин чадал нийлээд жилд ойролцоогоор 80 сая тонныг олборлох боломжтой гэж IMC Montan олон улсын зөвлөгөө өгөх компаниас таамаг гаргажээ. Эдгээр ордыг ашиглаж эхэлснээр эхний ээлжинд Оросын ган үйлдвэрлэгчдэд коксжих нүүрс нийлүүлэх, мөн илүүдэл нүүрсийг Оросын алс дорнодын далайн боомтоор дамжуулан ЗХА-ийн зах зээлд экспортлох зорилт тавьж байна. Эдгээр ордыг ашиглаж эхэлснээр коксжих болон эрчим хүчний нүүрсний нийлүүлэлт ихсэх, оросын төмөр зам болон далайн боомтын ачаалал ихээр нэмэгдэх төлөвтэй байна. 2012 оны 5 дугаар сард ОХУ-ын ерөнхий сайд Хакасын Бүгд Найрамдах Улсын Кызыль-Курагино чиглэлийн 402 км урт төмөр замын шав тавих ёслолд оролцсон. Шинэ төмөр зам ашиглалтанд орсноор Тувагийн Элегестийн коксжих нүүрсний уурхайгаас нүүрс тээвэрлэх боломжтой ба төмөр замыг 4 жилийн хугцаанд барих юм байна. Харин манай өмнөд хөршийн хувьд нүүрс ихээхэн эрэлттэй байна. 2012 онд Хятад 3,7 тэрбум тонн түүхий нүүрс олборлож, 525 сая тонн коксжих нүүрсний баяжмал үйлдвэрлэсэн нь дэлхийн коксжих нүүрсний үйлдвэрлэлийн 50 гаруй хувийг эзэлж байна. Зөвхөн ӨМӨЗО-ны нутаг дэвсгэрээс 2012 онд 1 тэрбум орчим тонн нүүрс олборлосон нь Хятадын нүүрсний үйлдвэрлэл хэр хурдтай өсч байгааг харуулж байна.

Монгол майнинг корпорацийн тооцож буйгаар Хятадын коксжих нүүрсний эрэлт 2015 онд 2012 оны түвшинтэй харьцуулахад эрэлт

Зүүн хойд азийн нүүрсний эрэлт ба нийлүүлэлт

хэрэгцээ даруй 7 хувиар өсөхөөр таамаг гаргажээ.

Хятад улс 2005 оноос эхлэн нүүрсний жижиг уурхайнуудыг хаах, импортын татварыг бууруулах, экспортын татварыг нэмэгдүүлэх гэх мэт олон үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлснээр өнөөдөр Хятад улс нүүрс экспортлогч орноос импортлогч орон болж байгааг дараах тоо баримтаас үзэж болно.


2003 онд Хятадын нүүрсний импорт жилд 10 сая тонн байсан бол 2007 онд 51 сая тонн, 2009 онд 126 сая тонн, 2011 онд 184 сая тоннд хүрч импортын хэмжээгээр Японы өмнө гарч дэлхийд тэргүүлж эхлэв. Харин Хятадын нүүрсний экспорт нь 2003 онд 100 сая тонн байсан бол 2011 онд 3 сая тонн хүртэл буурчээ.

Хятад улс төрийн бодлогоор нүүрсний олборлолтыг хязгаарлаж байгаа нь тухайн зах зээл дэхь нүүрсний хэрэгцээг нэмэгдүүлж, импортыг өсгөж байна. Энэ нөхцөл байдал нь хөрш зэргэлдээ ОХУ, Монгол, Вьетнам зэрэг орны хувьд өөрсдийн нөөц баялаг, давуу талаа ашиглах томоохон боломж бий болгож байна.

Хятадын коксжих нүүрсний эрэлт

Хүснэгт 4.

(сая тонн)



Эх сурвалж: ММС

ДҮГНЭЛТ:

Олон улсын эрчим хүчний зөвлөлөөс гаргасан таамгаар дэлхийд 112 жилийн хугацаанд ашиглах нүүрсний нөөц байна. 2035 он хүртэл хугацаанд нүүрс нь дэлхийн хэмжээнд ихээхэн эрэлттэй түүхий эд байх төлөвтэй байна. 2011 оны үзүүлэлтээр дэлхийн нийт нүүрс олборлолтын талаас дээш хувь ЗХА-ийн орнуудад ноогджээ.

Хэдийгээр ЗХА бүс нутаг дэлхийд нүүрсний олборлолтоор давамгайлж байгаа ч Хятад, Япон, Өмнөд Солонгос зэрэг оронд нүүрсний хэрэгцээ их, цаашид ч өсөх хандлагатай байна. Үүнтэй уялдаж ОХУ-ын эрчим хүчний шинэ стратегийн¹² дагуу оросын нүүрсний экспорт алгуур алс дорнод тийш ЗХА-ийн зах зээлд чиглэж байна.

Монгол улсын хувьд нүүрсний нөөц их, гадаад зах зээлийн эрэлтээс хамаарч экспорт өсч байна. Засгийн газраас нүүрсний олборлолтын хэмжээг 2025 он гэхэд жилд 75 сая тоннд хүргэх зорилт тавьсан. Нүүрсний экспортыг дорвитой нэмэгдүүлэхэд төмөр замын дэд бүтцийг өргөтгөх асуудал чухал юм. Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого батлагдаж энэ дагуу төмөр замыг өргөтгөх, барьж байгуулах ажил эхэлж байна.

Орос-Хятадын нүүрсний салбарын хамтын ажиллагаа өргөжсөн, ОХУ-ын засгийн газар Сибирь дэх нүүрсний ордуудаа ашиглаж эхэлж байгаа зэрэг нь ойрын хугацаанд Хятад болон ЗХА-ийн зах зээлд ОХУ-нь нүүрсний гол нийлүүлэгч болох хандлагатай байна. Улмаар нөөц баялаг болон газарзүйн ойрдот байршил зэргээс хамаарч Монгол, ОХУ-нь ЗХА-ийн зах зээлд нүүрс экспортлогчид төдийгүй гол өрсөлдөгчид байх төлөвтэй байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

¹ www.worldenergy.org

² <http://ajw.asahi.com/article/economy/business/AJ201205090074>

³ China Customs Statistics

⁴ Trade Statistics of Japan

⁵ Korea Trade statistics

⁶ Монгол улсын гадаад худалдааны барааны статистик мэдээлэл-2011. УГЕГ

⁷ “Өнөөдөр” сонин. 042\4806\ . 2013.02.22. Нүүр хуудас

⁸ “Российско-китайские переговоры”. www.kremlin.ru/news

⁹ “China, Russia ink agreements on energy cooperation”.www.

china.org.cn\world\2012-12\05\

¹⁰<http://www.energyandcapital.com/articles/russia-china-agree-to-6-billion-deal-for-475-million-tonnes-of-coal/1265>

¹¹ <http://www.vestifinance.ru/articles/9161>

¹² Энергетическая стратегия России на период до 2030 года.
www.energystrategy.ru

Abstract:

The world coal consumption has a tendency to grow till 2035 according to the surveys conducted by international research institutions. As per 2011, the North East Asia (NEA) region represents 53 percent of the world total coal production and 60 percent of the coking coal. Even though NEA dominates in the world coal production, the region's countries like China, Japan and South Korea are in greater demand of coal imports and outlook shows that their consumption will be growing in forthcoming years.

Mongolia has an enormous coal resources and its export volume is increasing year to year. As per new energy strategy, Russia's coal export is gradually moving towards Far-east aiming the NEA market. Current strong developments of Russia-China coal cooperation, and Russia's recent decision to develop resource-rich Siberian coal deposits once again proved that Russia can become coal exporter to the NEA in near future. Accordingly, NEA region's countries like Mongolia and Russia can be not only potential coal suppliers, but also export key competitors in the region's coal market due to their resources and proximity.

Key words: Northeast Asia, coal demand and supply, coal export, coking coal.